

Дүр урлалын шинэ зарчмыг
“Залуу хос” туужаас мөшгөх нь

Дэмбэрэлсүрэнгийн ЦЭВЭЭНДОРЖ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх ухааны академи,
Хэл зохиолын хүрээлэн, Утга зохиол судлалын салбар

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд зохиолч М.Ядамсүрэнгийн “Залуу хос” тууж дахь дүрийг урлах шинэлэг, өвөрмөц эрлийг түүний туурвил зүйн онцлогтой холбож тодруулан үзсэн болно. Ингэхдээ уламжлалт аргаар бус өрнө, дорнын хэл соёлд боловсорсны хувьд арга билгийн зарчмаар дүрүүдээ урласныг анх удаа тодотгохыг оролджээ. Нөгөө талаар энэхүү судалгаа нь М.Ядамсүрэн нарын зохиолчид Хятадын уран зохиолоос хуулбарласан бус гадаадын дэвшилтэт аргыг бүтээлчээр ашиглан үндэсний уран зохиолоо хөгжүүлэх алхам хийсэн гэсэн шинэ санаа дэвшүүлэв.

Түлхүүр үгс: Ядамсүрэн, дүр, Залуу хос, тууж, арга билиг

Exploring a New Principle of Figuring Characters in
“A Young Couples” Novella

TSEVEENDORJ Demberelsuren

Department of Literature Studies, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In this article, the author studied a new and exclusive research of characters to create and did poetic discriminating of “A young couple” novella by Yadamsuren M. Also first time explored characters of his novella by the concept of “Yin Yang” means not traditional methods educated to Western and Oriental language and cultures. Furthermore, early of 20th century writers likewise Yadamsuren M and others not reproduced by Chinese literature and a progressive achievement of foreign tried to develop for national literature of Mongolia. The novella “A young couple” by Yadamsuren M translated into English and published in US.

Key words: Yadamsuren, Character, Young Couples, Novella, Yin, Yang

* © Д.Цэвээндорж, 2025, Email: tseveendorjd@mas.ac.mn

1. Удиртгал

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчид аман болон бичгийн утга зохиолын боловсролтой, ихэвчлэн төвөд тэргүүт дорнын улс орнуудын хэлний мэдлэгтэй шинэ цагийн сэхээтнүүд байв. Тэдний нэг нь зохиолч М.Ядамсүрэн бөгөөд манж, хятад хэл бичигт багаасаа суралцаж, орос англи хэлд өсвөр наснаасаа боловсорсон хос морьтон юм. Өөрөөр хэлэхэд сэхээтэн гаралтай, гэр бүлээрээ бичиг үсгийн өндөр боловсролтой байсан нь зохиолч болоход нь нөлөөлсөн бөгөөд дүр, дүрслэлүүд нь сонгодог монгол хэлний найруулга, соёл боловсролын дэвшлийг хослуулснаараа өөрийн гэсэн өнгө аяс, туурвилыг үүсгэжээ.

“XX зууны монголын тууж бичлэгийн туурвил зүйд хятадын сонгодог бичгийн уламжлалыг амжилттай нэвтрүүлсэн хүн бол зохиолч М.Ядамсүрэн юм. Түүний бичсэн өгүүллэг, тууж нь хятадын сонгодог бичгийн найруулгыг монгол утга зохиолд амжилттай хэрэглэсэн” (Байгалсайхан, 2014:56-57) хэмээн дүгнэн тодорхойлогдож байв. “Залуу хос” тууж 2021 онд Америкт англи хэлнээ орчуулагдан хэвлэгдсэн бөгөөд хуучин нийгмийн хоцрогдлыг “Турван хүүхэн” тууждаа дүрсэлсэн бол шинэ нийгмийн дэвшлийг “Залуу хос” тууждаа дэвшүүлсэн онцлогтой юм. М.Ядамсүрэн гуч гаруйхан насалсан ч Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэгд тооцогддог нь зохиолч, сэтгүүлч, шүүмжлэгч, нийгэм олон нийт, соёлын зүтгэлтэн гээд цөөнгүй салбарт бүтээлчээр ажилласантай нь холбоотой тул нэгэн зохиолоор нь жишээлэн дүрийн урлал, туурвил зүйн онцлогийг нь тодруулан авч үзье.

2. Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших аргуудыг зохиолч М.Ядамсүрэнгийн “Залуу хос” туужид тулгуурлан гүйцэтгэв.

3. “Хуулбар” зохиол гэж дүгнэх хуудуутай болох нь

Гагц М.Ядамсүрэнгийн гэлтгүй энэ үеийн зохиолчдыг дорно дахин, хятадын бичгийн зохиолын нөлөө тусгалыг хуулбарласан гэж гадаад, дотоодын судлаачид (Ван Мандуга г.м) өнөө цагийн өнгөн дээрээс эдүгээчлэн авч үзэх нь учир дутагдалтай бөгөөд хятад, манж бичигт боловсорсон шинэ цагийн тэргүүн сэхээтний хувьд М.Ядамсүрэн, Д.Бодоо нар шинэ цагийн уран зохиол нь гагц орос, өрнийн соёл боловсролд шимтэх төдийгүй дорно дахины уламжлал, үгээр урлах, дүрээр зураглах чадварыг ч хожмын зохиолчид хослуулах нь зүйтэй гэсэн санааг суурилуулсан хэмээн үзэж байна. Энэ нь шинэ цагийн бичгийн найруулгад сонгодог жишээ болж байсныг М.Ядамсүрэнгийн хувийн захидал, “Ухваргүй ярилцаан”, “Залуу хос” тэргүүт бичиг зохиол нь бататгадаг юм. М.Ядамсүрэнгийн шүүмжид: “Ер хүн төрөлхтний соёл боловсролын хөгжилт нь тус тус өөртөө үндэсний онцлог байдалтай... авч олон улсын хоорондын харьцааны бие биедээ нөлөө туршлагыг өгч байдгаас нийтийн соёл түргэн хөгжиж чадах юм” (Ван Мандуга, 1999:501-503) хэмээн утга зохиолын онолын үзэл баримтлалаа тодорхойлж байсан нь үүнийг гэрчилдэг бөгөөд арга билиг, өрнө, дорнын арга зүйг хослуулах зарчимтай нь нийцэж байна.

Өөрөөр хэлэхэд өрнө, дорнын утга зохиолтой өв тэгш танилцан бүтээлчээр суралцахыг чухалчилж асан нь бичгийн боловсролтой хүн цөөн, хаанахын ямар зохиолын өгүүлэмжийг дуурайн бичсэнийг тухайн үед бүгд мэддэг тул тулгар цагийн утга зохиолд зохиомж, аргын шинэ туршлага нэвтрүүлсэн талаас нь авч үзэх нь зүйтэй хандлага юм. Нэг ёсондоо үүсэн хөгжиж буй шинэ утга соёлд шинэхэн мэдлэг түгээхийг гадаад хэл сурсан сэхээтнүүдийн цаг үеийн үүрэг талаас тайлбарлах нь зүйтэй байр суурь мөн. Энэ нь дуурайж бичсэн гэх зохиол нь хятад эхээрээ монголын цөөн сэхээтний гэрт дэлгээтэй байснаар тайлбарлагдана. Нөгөө талаар дорно дахин, хятадын бичиг үсгийн соёл тухайн үедээ тэргүүлэх чиглэлтэй байсныг XX зууны орос, XXI зууны англи хэлт өрнөдийн соёл боловсролоос бүтээлчээр суралцаж ирсэн түүхэн туршлага харуулдаг. Монгол зохиол, зохиолчдыг үгүйсгэх бус харин ч бичгийн хэлтэй зохиолчид энэ жишгээр зохиол туурвиж гэмээнэ шинэ цагийн уран зохиолыг арга, билгийн зарчмаар өв тэгш бүтээж болох юм гэсэн үндэс суурийг тавьсан гэж үзэх үндэслэлтэй. Өөрөөр

хэлэхэд Орос, өрнөдийн утга зохиолоос бүтээлчээр суралцсанаа бахархаж тэмдэглэдэг атлаа Хятад, дорнын утга зохиолыг танилцуулан жишээлснийг үгүйсгэж болохгүй юм. Жишээ нь тус туужид эмчийг “доктор” гэж бичсэнийг дэвшил талаас нь хардаг шигээ хятадаар бичсэн бол жигших байсан нь үүний баримт мөн.

4. Уран сайхны үнэ цэн, нөлөө

“Залуу хос” тууж нь зохиомжийн хувьд “даруй эргэж Жалцан охин хоёрын үнэн учрыг үзсүгэй, “...Гэвч мань залуу Жалцан арай энэ муу хэргийг дахин үргэлжлүүлэхгүйгээр зөвхөн янаг охинтой учирч чадах буй за. Энэ сул үгээр юу хийх вэ. Гагцхүү залууст санамж болгоно” (Түдэв, 2005:104) гэх мэт туужийн өгүүлэмж нь нэвт сүлжилдсэн бус тайлбар дагалдуулснаараа цохолбор шинжтэй дорнын аястай ч хариу захидал, хариу шүлэг шигтгэсэн нь зохиомжийн хувьд өвөрмөц, тухайн үеийн сонирхолтой бүтээлд тооцогдож байсан нь М.Ядамсүрэнгийн гадаад зохиол бүтээлтэй гүнзгий танилцсан мэдлэг, шинэ эрэлхийлэлтэй холбоотой болно. Жишээ нь:

“Зуны улирлын өнгөт цэцэг

Байгалийн дүрсийг элдвээр чимэглэнэ

Залуу хүний уянгат захидал

Миний сэтгэлийг элдвээр хөдөлгөнө” (Түдэв, 2005:121) гэсэн хариу захидал нь дүрийн догдлол, эргэцүүлэл, хүсэл тэмүүллийг илэрхийлж буйгаараа үнэ цэнтэй байна.

Мөн “Тэнгэрийг эсгэсэн мэт шөнийн хөмсгөн сар үнэхээр саваагүй тул үүлийн завсраар сэмхэнээ шагайж хараад дэмий л мөшөлзөн инээнэ” (Ядамсүрэн, 1937:60-61), “сэтгэлийн дотор хүслийн гал бадарч нүдний үзүүрт янагийн бүжиг наадан зүрхний төвд зоригийн хөвч зангирна” (Москва, 1937:6) хэмээн шүлэглэлт өгүүлэмж, өгүүлсэн шүлэг мэт өгүүлбэрүүд бүхий яруу сайхны дүрслэл бий нь зохиолчийн бүтээлч сэтгэмж, уран чадвараар тайлбарлагдана. Туужийн үйл явдлын шугам тэр чигтээ бие, сэтгэлийн эрэл байдаг. Тиймээс дэд хэсгүүд нь “Үл үзэгдэх цахилгаан зай”, “Үл мэдэгдэх хариу шийдвэр”, “Үл олдох түргэн уналга”, “Үл шоолох хөгшин улиас”, “Үл мартагдах өвгөний үг” гэсэн нэртэй нь санаандгүй бус бөгөөд уран чадвар, туршлагын хувьд тэгширч зохиол туурвилдаа нягт нямбай хандаж төлөвлөгөөтэй бичиж байсныг илтгэдэг. Өөрөөр хэлэхэд анхны харцаар дурласан сэтгэлийг “үл үзэгдэх цахилгаан зай”-гаар төлөөлүүлсэн сэтгэмж ажиглагддаг.

Харин “Эр хүний сэтгэл цэнгэж өнгөрүүлсэн жилийг богино хэмээн чамлах бөгөөд зовж өнгөрүүлсэн цагийг урт хэмээн гасална” (Ядамсүрэн, 1937:23), “Үнэхээр хүний сэтгэл мэргэн бөгөөтөл мунхаг мэт, тодорхой атал бүрхэг мэт явах нь алив хэрэгт аль олон тохиолддог биш үү” (Түдэв, 2005:109) зэрэг уншигчдад өгөх ухаарал, эргэцүүлээрээ “Залуу хос” туужийн уран сайхны үнэ цэн илүүтэй жин дарж бие даасан өгүүллийн хэмжээнд судлагдахуун болж байна.

5. Нийгмийн үнэ цэн, ач холбогдол

Шинэ нийгэмд өөрсдийн хүсэл, хувиршгүй хайр сэтгэлээр шинэ хосууд бий болж буйгаар цаг үеийн тусгал, хуучныг халж, шинэ соёлд нэвтэрч буй нийгмийн үзэл санааг тусгасан юм. Өөрөөр хэлэхэд “Залуу хос” тууж зөвхөн хоёр залуугийн тухай бус нийгмийн шинжтэй өргөн агуулгатай болохыг дараах хэдэн санаанаас харж болно.

1. Бичлэг, зохиомжийн хувьд дорно дахин, хятадын уран зохиолоос бүтээлчээр суралцсан мэт ерөнхий төлөв ажиглагдах ч сэдэв, санаа нь эх орон, нийгмийн чухал асуудлыг хөндөн дэвшүүлснээрээ онцгой ач холбогдолтой байна. Өөрөөр хэлэхэд шинэ цагийн залуусын сэтгэл нь үнэн, мөр нь тунгалаг эхэлж буйг үзүүлснээрээ М.Ядамсүрэн зохиолч нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэнд зохиолын үнэ цэн оршино.

2. “Гагцхүү Жалцан алба тарж гэртээ ирвээс хар цоож хаалгын хажуунаа унжиж...” (Ядамсүрэн, 1991:3) гэх зэргээр гагц бие залуус нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага бага гэсэн санааг илэрхийлснээрээ өргөн хүрээ, том агуулга илтгэдэг. Энэхүү өгүүлбэр 112 үгээс

бүрдсэн байгаа нь дорно, өрнийн хэл боловсролыг эн тэнцүү эрхэмлэж арга билгийн зарчмаар утга төгс эвсүүлэн найруулж байсны баримт юм.

3. Хайр сэтгэлийн сэдэвт эл шүлэгт нийгмийн байдлыг төлөөлүүлсэн далд битүү утга (“салхин зулыг унтраав” г.м), “Хагас шаазан цайнд хоёр ялаа унаж үхсэн” (Ядамсүрэн, 1991:3) бэлгэдлийн, төлөөлөл дүрслэл нь залуу хүн нийгмийн хүч ч юм, золиос ч юм гэсэн санааг хөндсөн хэмээн үзэж байна.

4. Хүрээний хүүхнүүд олширч өвчний үүр, нийгмийн тээг болж байсныг нүдээр үзэж “Гурван хүүхэн” туужаа бичсэн нь энэхүү зохиолд бас залгамжилсан. Өөрөөр хэлэхэд эдгээр зохиолыг “холбоо тууж” хэмээн үзэх нь зохиолчийн эгч ч энэхүү гашуун түүхийг тойроогүй, дайрч өнгөрсөнтэй холбоотой бөгөөд тухайн нийгмийг тольдгон харуулж хожмын үйлсэд сургаж, сайн сайхны үлгэр загвар болохуйц өргөн агуулгатай, үнэ цэнтэй зохиол болгожээ.

5. Гагц бие залуу Жалцангийн гэрийн эмх цэгцгүй байдлыг нарийвчлан дүрсэлснийг доктор Ван Мандуга байгальч (натуралист) үзлийн аргаар бичсэн (Ван Мандуга, 2015:58) гэж үзсэн нь бий. Бидний хувьд зохиолын үзэл санааг тодотгох үүднээс ихэд анхаарал хандуулж бичсэн нь тухайн үеийн нийгмийн байдал ороо бусгаа байсныг (1937) энэхүү эмх цэгцгүй байдал, тогтворгүй санаа сэтгэл, хөөцөлдөөнт үйл явдлаар харуулсан гэсэн шинэ санааг дэвшүүлж байна.

6. Учир нь энэ мэт үймээн самуун бусад зохиолууд, жүжиг (“Халхын баатар” г.м)-т нь нарийвчлан дүрслэгдсэн нь бий. Мөн реалист бус аргыг С.Буяннэмэх нарын хамт цөөнгүй уран бүтээлчид туршин хэрэгжүүлсэн нь нийгмийн цонхыг нээгдүүлэх шинэ эрэлхийлэл болж байсан хэмээн үзэж буй болно.

7. “Ухваргүй ярилцаан” өгүүллэгийг нь амьдралаас тасархай, шинэ цагийн үзэл санааг тусгаагүй, “Гурван хүүхэн” (1936) тууж шинэ хүний дүрийн хүмүүжил нөлөөнд сөрөг нөлөөтэй зэргээр үзэл суртлын үүднээс мушгин гуйвуулж байсан ч эдгээр зохиолууд нь тухайн цаг үедээ “Залуу хос” туужийн адил нийгмийн өндөр ач холбогдолтой байсныг үгүйсгэх аргагүй болно. Нөгөө талаар зохиолч ч туршлага нимгэн байсныг бодолцох ёстой.

6. Дүрийн урлал

Уг туужид сонгодог бичгийн уран зохиол, дорно дахины дүрийг хөрөглөх уламжлалыг гүйцээж шинэ эрэлхийлэл хийсэн юм. Жишээ нь: “Харавтар өнгийн үс нь тас хар бус боловч үзэхэд зохистой, бумбын гэрэлт царай нь дүгрэг атлаа бас төвшин эелдэг хэвтэй. Ялгаран улайж гэрэлтсэн уруул, хацар нь алим жимснээс юуны өөр ажээ. Эргэн наадах мойлын хар нүд нь эр хүний зүрхийг харваж шархлуулан эгнэгт соронзон адил татаж ямагт инээх баясахыг завдана” (Түдэв, 2005:100) хэмээн дүрсэлсэн нь их сударч В.Инжаннаши тэргүүтний бичгийн эрдэм, дүрээ гаднаас нь хөрөглөх, дотроос нь ургуулах аргыг хослуулсан уламжлал болох нь илт байна. Өөрөөр хэлэхэд эх хэлний гүн утгад нэвтэрч дүрийг нарийвчилж зураглах дорнын уламжлалт шидээр шүлэглэсэн мэт яруу бүтээсэн нь зохиолчийн уран сэтгэмжийг илтгэдэг.

Улмаар “түүний дээдэд зурсан адил хөмсөг нь шөнийн сар тэнгэрийг эсгэсэн мэт уран сайхныг өөр адилтгах зүйлгүй. Сая дэлгэх цэцгийн цоморлиг адил ам нь тэгш нээгдэж, дээд доод уруулдаа эелдэг инээдийн урныг хадгалжээ” (Түдэв, 2005:100) хэмээн дүрээ хөрөглөн зураглахын зэрэгцээ “Ийнхүү гаслах, баярлах, уурлах, инээх, яарах, мөрөөдөх...” гэсэн сэтгэлийн зургаан туйлыг нэгэн биед хурааж энгийн тоочих бус сэтгэл зүй, догдлолоор нь дүрээ дотроос нь дэлгэж үзүүлсэн нь судлаачдын анхаарлыг татаж байгаа юм. Мөн “...бичгийн савыг ширээн дээр тавьж дугуйгаа түлхэн гаргаад хадгалан хүлээгч хар цоожиндоо хаалгыг тушаан баруун зүг одов” (Ядамсүрэн, 1937:4) хэмээн дорно дахины найруулгад боловсорсноо бататгаж хар цоож хэмээх төлөөллийн, бэлгэдлийн дүр, дүрслэл бүтээснээрээ ялгарч байна.

6.1. Дүрийг урлах арга билгийн зарчим

Арга билиг (деаликтик) нь Эртний Энэтхэг, Хятад тэргүүт дорно дахины утга соёлд түгээмэл ойлголт бөгөөд аливаа зүйлийн үндсэн хоёр шинжийг төлөөлүүлэн авч үздэг. Өөрөөр хэлэхэд эр эм, хатуу зөөлөн, өндөр нам гэх мэт. Энэ утгаараа Европын утга зохиолыг арга, дорно дахиныг билиг хэмээн авч үзэж буй болно. Өөрөөр хэлэхэд бодит ахуй, хийсвэр санаа зэрэг гүн ухааны үүднээс зохиолыг судлах баримтлал юм. “Мэргэд гарахын орон”-д аргын хувь, билгийн хувь гэж тэмдэглэсэн байдагчлан их сударч В.Инжаннаши “арга билгийн амьдрал бүхий хүмүүн төрөлхтөн”, “орчлон хэмээгч нийтээр арга билгээс бүтжээ. Арга билгийн хоёр амьсгал бүхий газарт хүн амьтан төрж үүсмүй” гэх зэргээр “Хөх судар” романдаа бичсэн байдаг. Эрдэмтэн Ц.Хасбаатар “Арга билиг бол “эсрэг тэсрэгийн нэгдэл” гэсэн утгатай гүн ухааны томьёолол юм. Энэ томьёоллыг идеалист сургаалаар аргыг “бодис”, билгийг “сэтгэл” гэж тайлбарласан зүйл Энэтхэгийн гүн ухааны номд бий” (Хасбаатар, 1996:164) хэмээн тэмдэглэжээ. Иймд “Залуу хос” туужид агуулга, санааны хувьд арга буюу өрнө, бичлэг туурвил зүйн хувьд билиг буюу дорнын арга барилыг шүтэлцүүлж, ахуйч, байгальч үзлийг нөхцөлдүүлсэн ч сэтгэлийн буюу хүний, биеийн буюу нийгмийн талаас нэгтгэн авч үзсэнээр нь онцолж буй юм. Эрдэм боловсрол байгаад авьяас үгүй бол хол явдаггүйн адил аливаа зүйлийн гэрэл сүүдрийг тэнцүүлж, ил далд мөн чанарыг эргэцүүлэлгүйгээр бүрэн ухаарах боломж хомс байдаг. Үүнд “Залуу хос” туужийн туурвилын уран чадвар оршиж буй юм.

6.2. Дүрслэлийн уран сайхан

Жалцан “олны байдлыг ажиглаж хаврын сэтгэлийн уйтгарт бухимдан сэрээ хутгыг харшуулж, ширээний бүтээлгийг имрэн суутал” (Ядамсүрэн, 1991:4), хэмээн гол дүрийн ганьхралыг тодорхой дүрсэлсэн бол охины өмссөн зүүсэн “Европ охидын зэргээс хэтэрчээ” гэсэн нь зохиолчийн өрнийн соёлд боловсорсныг буюу тухайн үеийн ЗХУ-д суралцаж англи хэл сурч байсныг нь давхар илтгэсэн гэж үзнэ. Энэ мэт “...хөдөлгөөнөөр бүрдээд чимээгээр дуурьсана” (Түдэв, 2005:100), “Энэ дотор залуу Жалцан ормогц нэгэн мөчийн өмнө гасалгаж агсан чимээгүй гүний уйтгар хэдийнээ устаж...” (Ядамсүрэн, 1991:4) хэмээн зохиолын эхэнд ганцаардаж байсан гэсэн санааг өгүүлэгчийн болон баатрын хэлээр илэрхийлэлгүй зөвхөн том хар цоожтой тухгүй гэрийг дүрсэлснээ ийн тайлал хийж “үг алдсан мэт” урнаар төлөөлүүлсэн нь ажиглагддаг. Тодруулбал “цацран бэлчих сэтгэлийг тогтоон хариулж чадахгүй гайхаш алдран байж бачим амьсгалд чичирхийлэн бүхий гараар захидлыг битүүмжлэв” (Ядамсүрэн, 1991:12) зэргээр сэтгэл хэмээх асар их хүчийг онож хэлэхдээ эгэл энгийн зүйлсийг нарийн тодорхой дүрсэлсэн нь зохиолчийн уран чадварыг илтгэж байна. Эдгээрийг:

Тодорхойлол: “Үнэхээр хүний сэтгэл гэгч үзвээс дүрсгүй, хүрэлцвээс биегүй, сонсвоос чимээгүй атлаа нэгэн эгшинд түмэн зүйлийн хэргийг бүтээн устгаж чадах нь маш гайхамшиг”,

Хэтрүүлэл: “Жалцаны цээжийг шарх гартал нэвтлэн харж доторх зүрхийг маажсаар”,

Эсрэгцүүлэл: “Ийм залуу эрэгтэй, эмэгтэй хоёрын завсар үл үзэгдэх цахилгаан зай гүйж танилцаагүй атал хүсэлцэн, хүрэлцээгүй атал догдлон харилцан биеийн халуун зүрхийг шархлааж сэтгэшгүй ноцох, өгүүлшгүй ихээхэн хөдөлгөөнийг хоолны газар байсан олон хүмүүс юун олж мэдэх билээ”,

Цаг хугацаа: “Ийнхүү хэдэн мөчийг халуун жигнүүрт суусан ялаа адил нэн ч тогтворгүйгээр өнгөрүүлж ядан” (Ядамсүрэн, 1937:8),

Учир шалтгаан: “...цай хоол болж зүдэрсэн ядарсныг асуух зэргээр залуу эрэгтэй эмэгтэй хоёр мөн харилцан бие биеийг урхилж янаг үгсээр шөнийн хэргийг зөгнөн амраг сэтгэлээр харилцан биеийг асрамжилна” гэсэн хэсгүүдээр ангилан тодруулж болохоор байна. Олон төрөл хэлбэрийн эдгээр дүрслэлүүд нь зохиолын үзэл санаа, дүрийн зан төрхийг илтгэхэд бие даасан шинжтэй бүтээгдсэнээрээ онцгой үүрэгтэй юм.

7. Хэл найруулгын онцлог

Үгийн сонголтын хувьд “Имбэрүү гоо”, “Атга нойр авч өглөө эртлэн босож явцгаая” (Ядамсүрэн, 1991:29) зэрэг уран дүрслэлт, оновчтой үгсийг сонгохын зэрэгцээ “Санан баярлаж, баярлан санана” (Ядамсүрэн, 1991:40) хэмээн холбоо үгийн байрлалыг сольж санаагаа эрчимжүүлэн бичдэг найруулгын онцлог нь уг туужид “...дэмий л сандран баясч, баясан сандармуй” (Ядамсүрэн, 1937: 41), “...ханын сонин, уран зохиол, уран сайхан хэмээн ярилцан хүсч, хүсэлцэн яримуй” (Ядамсүрэн, 1937:67) зэргээр залгамжилжээ. Мөн “Хоёр бие нэгэн дээлийн дотор удаан өдрийн зузаан мөрөөдлийг ярилцана...”, “Тэнгэрийг эсгэсэн мэт шөнийн хөмсгөн сар үнэхээр саваагүй тул үүлний завсраар сэмхнээ шагайж хараад дэмий л мушилзан инээнэ” (Ядамсүрэн, 1937:60-61) хэмээн адилтган зүйрлэх ил сул бус нууц янагийн үйлийг далд хэвээр үлдээсэн нь зохиолчийн уран чадвараар тайлбарлагдах юм.

Тухайн үед утга зохиолын хэлний тухай хуучныг бүр мөсөн халах, эсхүл тэр чигт нь хэрэглэх хоёр талт туйлшрал нүргэлж байхад М.Ядамсүрэн хуучин бичгийн хэлийг шинэ утга зохиолын шаардлагад нийцүүлэн боловсруулах нь зүйтэй гэсэн голч зарчим баримталж байснаа зохиол бүтээлдээ нэвтрүүлсэн нь ийн тодорхой болж байна.

Тиймээс эх хэлнийхээ цэвэр ариун байдлыг эрхэмлэж бичсэн шүүмжид: “...бид нар хуучин соёл боловсролыг бүрнээ түймэрдэн арилгаж, огт хэрэглэхгүй устгах буюу өөр шинэ тус тусаар тулгар зохион байгуулах хэмээн үл болно” (Ядамсүрэн, 1991:31), “Үнэхээр хүн төрөлхтний бүтээн үйлдсэн соёл боловсролын аль хэрэгтэй тусгайг нь өөрийн зорилгодоо тохируулан авч хэрэглэх ёстой” (Ядамсүрэн, 1934:3) хэмээн өв уламжлалаа нандигнахын чухлыг тэмдэглэн бичиж байсан нь зохиолын чанар чансаа, хэлмэгдэлт аль алинд сайн, муугаар нөлөөлсөн юм. “Хэдийгээр цагаадсан ч үндсэрхэг үзлийн тусгал буй” хэмээн НТХ-ны нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэн ярьсан нь зохиол бүтээл нь дарагдсаар ирснийг илтгэх тул М.Ядамсүрэнийн уран бүтээлийг зөвөөр үнэлэн судлах цаг үеийн шаардлага байсаар буйг мартаж болохгүй.

Түүнчлэн “...эрхэм нарийн зэвсэг уран зохиолыг чухалчлан хэрэглэж улмаар олон нийтийн оюун ухаан боловсрол хичээлийг нээгдүүлэн татах нь нэн чухал” (Ван Мандуга, 1999:486-491, 1934 оны 2-р хугацаанд) гэснээс үзэхэд М.Ядамсүрэн урлаг уран зохиолын үндэсний, олон нийтийн, үзэл суртлын талыг голлон анхаарч байсан нь ажиглагддаг. Энэхүү үзэл баримтлал “Улсын төв театрын анхдугаар дотоод уралдаан ямар болсон тухай өчүүхэн тэмдэглэл” (“Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл, 1934), “Дуулах хөгжимдөхийн тухай өчүүхэн сануулга” (мөн тэнд, 1934), “Үндэсний уран сайхны ажлын онц бүтээлтэй уралдааны тухай” (“Ардын үндэсний эрх”, 1934), “Уран сайхны хөгжил ба түүхий ажилчдын зүтгэл” (мөн тэнд, 1935), “Жүжгийг хэрхэн үзвээс амттай бөгөөд ашигтай вэ” (Үнэн, 1937) зэрэг шүүмж өгүүллүүд нь тодорхой туссан байдаг нь түүний арга, туурвилын өвөрмөц нэгэн өв болно.

Тиймээс энэхүү тууж монголын орчин үеийн уран зохиолд хүүхдийн уран зохиол, насанд хүрэгчдийн утга зохиолын зааг дахь өсвөр залуусын уран зохиол (young adult literature) хэмээх ерөнхий ангиллыг үүсгэсэн анхдагч зохиол гэсэн шинэ санал дэвшүүлж байна. Энэхүү ангиллыг номын санчид анх дэвшүүлсэн ч сэдэв, хүрээний хувьд “young adult- fiction”, “young adult romance” зэрэг ангилагддаг нь яахын аргагүй бие даасан төрөл хэлбэрийн хүрээнд үүрэг, зориулалт нь дэвшигдэж түгээмэл дэлгэрч буйн баримт юм. Энэ төрлийн зохиол нь хүүхдийн зохиол шиг дандаа аз жаргалтай төгсдөггүйгээрээ онцлогтой болно.

8. Дүгнэлт

1.М.Ядамсүрэн бичгийн боловсрол өндөр, билиг авьяас хурц тул “Тавьяат уран зохиолч” шагнагдаж гуч гаруйхан насандаа дөрвөн номоо хэвлүүлсэн зэрэг нь хожмын нэртэй уран бүтээлч болох зам гэгээтэй байсны баталгаа болно. Д.Намдагийн зохиолыг голтой шүүмжилсэн тэргүүтнээс үүтгэхэд уран бүтээлийн далайцаараа тухайн үеийн Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн нараас хол дутахгүй байсныг илтгэдэг.

2.Гэвч С.Буяннэмэх, Ц.Өлзий-Очир нарын хамт 1937 оны 9-р сард баривчлагдаж 10-р сард хилсээр хороогдон гуч гаруйхан жил амьдарсан тул түүний зохиол бүтээлүүдийг олон жил

туурвин бичиж туршлагажсан алдартай, шагналтай зохиолчидтой жиших аргагүй юм. Хүний хувьд төвшин сайн, шударга үнэн үгтэй байсан нь сайн зохиол бичих, бас хилсээр хэлмэгдэхэд нь ч нөлөөлсөн бололтой байна.

3.Шүлэг, хүүрнэл, жүжгийн зохиол, судлал шүүмж гээд утга зохиолын үндсэн төрлүүдээр жигд туурвисан нь зохиолынхоо чанар чансааг сайжруулахад нь түлхэц үзүүлжээ. Ялангуяа урлаг, утга зохиолын судлал шүүмж бичиж онол, арга зүйн үлгэр жишээ үзүүлж эхэлсний хувьд зохиолоос зохиолд олон талаар гүнзгийрч байсан нь ажиглагдаж байна.

4. Зохиолчийн зураг, амьд дуу хоолой бүхий дурсамж яриа нь пянз бичлэгт хадгалагдан үлдсэн нь түүний судлалд үнэтэй хувь нэмэр оруулах учиртай. Олдоогүй бүтээлүүдийг нь эрэн хайж илрүүлэх зэрэг баяжуулалт, бүрэн судалгаа хийснээр зохиол бүрийг төрөл зүйлээр нь тусгайлан нарийвчилж шинжлэх үүд хаалга нээгдэх юм.

5.М.Ядамсүрэн зохиолч үргэлжилсэн үгийн төрлөөр илүү амжилт олох байсныг түүний туужууд бататгадаг. Өөрөөр хэлэхэд шүлэг, жүжгийн зохиолоос туужууд нь дүрийг урлах, дүрслэлийг зураглах эрдмээрээ онцгойрч үндсэн төрөл болохоо илтгэж байна.

6.Ялангуяа “Залуу хос” тууж нь өгүүллэг, жүжгийнхээ дараа хэвлэгдсэн буюу хамгийн сүүлд бичсэн бүтээлүүдэд нь тооцогдох тул туршлагажиж, чанаржсаныг илтгэхийн зэрэгцээ сэдвийн хувьд ч шинэлэг нь лавлан асууж чадаагүй нэр зэрэг энгийн атлаа сонирхолтой ээдрээ, үйл явдлын өрнөлөөр гүнзгийрүүлж туурвисан зохиомж тэргүүтнээр батлагдаж байна.

7.Иймд “Залуу хос” туужийг хятадын уран зохиолын шууд нөлөөн дор бичигдсэн гэж үзэх нь учир дутагдалтай болно. Учир нь гадаадын хос залуусын сэдэвт уянгын зохиолтой харьцуулахад бие даасан ялгамжтай нь дорно дахин, нүүдэлч соёл сэтгэлгээний онцлогийг илтгэснээрээ онцгой жин дарж буйд оршино.

8. Гадаадын эл сэдэвт зохиолууд тодорхой хүний нэртэй (Ромео, Жульетта хоёр, Тристан Изольда хоёр г.м), өрсөлдөгч охид, залуус, гэр бүлийн дэмжлэг, бэлгийн амьдралын сонирхол зэрэг өргөн хүрээтэй хайрын түүх буюу өсвөр насныханд зориулагдсан, үлгэр жишээч болон муу хосуудыг ч тусгаж санамж сэрэмж үзүүлдэг бол “Залуу хос” тууж зохиолчийн уран чадварыг илтгэх дүр, дүрслэлийн уран сайхны зэрэгцээ нийгмийн хүрээтэй өргөн агуулга хөндсөнөөрөө үндсэн туурвил зүйг нь төлөөлөх зохиол хэмээн үзэж байна.

9. Эмэгтэй нь аялалд гарч осолд өртөхөд араас нь сэтгэл гарган очиж зам нийлүүлэн заяа холбож буй үйл явдал, зохиомж нь дэлхийн утга зохиолд монгол залуу хосын үнэнч сэтгэл, соёлын онцлогийг төлөөлөх хэмжээнд суурийг нь тавьсан уянгын зохиолын өвөрмөц туурвил болсон ач холбогдолтой юм.

Ном зүй

Байгалсайхан, С. (2014). *XX зуун тууж судлал* Улаанбаатар: [Baigalsaikhan, S. *Horidugaar zuuny tuuj sudlal*] [*Novel studies of 20th century*] Ulaanbaatar: 2014]

Мандуга, В. (2015). *Мөрдөндөвийн Ядамсүрэн*. XX зууны монгол зохиолчид боть №10. Улаанбаатар: [Manduga W *Mördendevyin Yadamsüren*. XX zuunii mongol zokhiolchid 10-r boti] [*Yadamsüren Mördendev Mongolian writers of 20th Century Volume 10*. Ulaanbaatar: 2015]

Мандуга, В. (1999). *Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. М.Ядамсүрэн “Өчүүхэн өгүүлэл” Монголын ардын үндэсний соёлын зам сэтгүүл 1934 №4-5. [Manduga, W. *Mongolyn orchin üyiin uran zokhiolyn sudlal shüümjlel*. Ovor Mongolyn Soyolyn khevleliin khoroo] [*Mongolian Modern literature study and criticism*. Inner Mongolian Cultural Publishing Committee.1999]

Түдэв Л., нар (ред.) (2005). *Монгол уран зохиолын дээжис*. Улаанбаатар: 14-р боть [*Mongolyn uran zokhiolyn deejis*]. [*Mongolian literature samples*]. Volume 14. Edited Tudev L., etal Ulaanbaatar: 2005]

Хасбаатар, Ц. (1996). “Арга билиг”. *Утга зохиол судлалын унших бичиг* [Khasbaatar, Ts. “Arga bilig” *Utga zokhiol sudlалын unshikh bichig*] [“Yin yang”- method of Wisdom. *A reader of Literature Studies* Ulaanbaatar: 1996]

Ядамсүрэн, М. (1934). Ардын үндэсний соёл боловсролын хөгжилтийн 13 ба арван жилд өнгөрүүлж ирсэн зам. “Монголын ардын үндэсний соёлын зам сэтгүүл” №5-6. Ван Мандуга Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. 1999. [Yadamsüren, M. Ardyn

ндесний соёл боловсролын хүгжлтийн 13 ба арван жилд өнгөрүүлж ирсэн зам [Thirteen of national education and cultural developments and a trodden path during the ten years] Ulaanbaatar: 1934]

Ядамсүрэн, М. (1937). “Залуу хос” Москва [Yadamsüren, M. *Zaluu khos*] [Yadamsüren, M. *A young couples* novel Moscow Ulaanbaatar: 1937]

Ядамсүрэн, М. (1991). “Залуу хос” (Эмхэтгэсэн С.Чимэдрэгзэн) Улаанбаатар: [Yadamsüren, M. *Zaluu khos*] [Yadamsüren, M. *A young couples* collected Chimedregzen.S] Ulaanbaatar: 1991]